

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм		<input type="checkbox"/> Үгүй			
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгалын эрсдлийн улмаас гуравдагч этгээдэд учирсан хохирлыг хариуцан арилгах даатгуулагчийн үүрэг, хариуцлага;					
	Даатгалын үндсэн эрсдэл	1. Даатгуулагч автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь насанд учруулсан хохирол; 2. Даатгуулагч автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эрүүл мэндэд учруулсан хохирол; 3. Даатгуулагч автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эд хөрөнгөд учруулсан хохирол.					
	Даатгалын нэмэлт эрсдэл	-					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1.0-3.0%					

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл бүрдсэн;
2. Даатгалын гэрээнд заагдаагүй эрсдлийн улмаас хохирол учирсан, даатгалын хамгаалалтад багтаагүй зардал;
3. Даатгуулагч болон түүний өмчлөл, эзэмшил, хараа хяналтад байдаг эсвэл даатгуулагчаар тээвэрлэгдэж байгаа хөрөнгөнд учрах хохирол;
4. Бичгээр зөвшөөрснөөс бусад хуулийн зардал үүнд хохирлын үнэлгээний зардал хамаарахгүй;
5. Даатгуулагчийн өөрийн ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэж байхад учрах амь нас, бие эрхтний гэмтэл бэртэл, түүнээс үүдэн гарах хариуцлага;
6. Хохирол учирсан талаар даатгагч болон эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэн шалгуулаагүй болон бусад шалтгаанаар хохирол учирсан шалтгаан тогтоогдоогүй, тодорхой бус байх;
7. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар нэхэмжилж байгаа дүн;
8. Нөхөн төлбөрийн баримтуудыг даатгагчид хүлээлгэж өгөх энэхүү гэрээнд заасан хугацаа дууссан;
9. Сайн дураар төлсөн болон хүлээн зөвшөөрсөн төлбөр, хохирол;

10. Даатгуулагчийн ажилтан тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох, тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулах эрхгүй, эрх нь хязгаарлагдсан, согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чадваргүй ядарсан, өвчтэй үед тээврийн хэрэгсэл жолоодсон;
11. Замын хөдөлгөөний дүрмээр тогтоосон тээврийн хэрэгслийн хурдыг хэтрүүлсэн, бүрэн бус тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцуулсан;
12. Уурхайн орчны дүрэм, журмыг зөрчсөн;
13. Даатгуулагч нь эрх бүхий байгууллага болон даатгагчийн шаардлага, сануулгыг биелүүлээгүйгээс учирсан хохирол;
14. Даатгалын гэрээгээр даатгалын хамгаалалтад хамруулахаар зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хүлээсэн алдагдал, олох байсан орлого, эдийн бус хохирол, байгаль орчинд учирсан хохирол;
15. Ан ав хөөх, уралдаан тэмцээнд оролцох, тээврийн хэрэгслийн хүчийг шалган турших, судалгаа, шинжилгээний ажлын явцад учирсан хохирол;
16. Монгол улсын нутаг дэвсгэрээс гаднах зам тээврийн ослын улмаас учирсан хохирол;
17. Дайн, зэвсэгт бослого, дотоодын үймээн самуун, террорист үйл ажиллагаа, ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр зэргийн улмаас үүссэн нөхцөл байдал, улс төрийн тэмцэлд оролцсоноос үүссэн;
18. Байлдааны зэвсэг хэрэглэх, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого мөн асбестос бодис ашигласнаас учирсан хохирол;
19. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл.